



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

Аймгийн Нийгмийн эрүүл мэндийн
төв байгуулах тухай

Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын 4.4.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 4.2.2, 15.1.6, 16.11, 24.6.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийг аймгийн "Нийгмийн эрүүл мэндийн төв" болгон өөрчлөн байгуулсугай.

2. Аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрмийг нэгдүгээр, үйл ажиллагааны чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Зарим аймгийн Эрүүл мэндийг дэмжих төвийн барилгыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн зориулалтаар ашигласугай.

4. Аймгийн Засаг даргатай зөвшилцөн аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтцийг батлуулж, төв байгуулан ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт, бүтцийн өөрчлөлттэй холбоотой шаардагдах хөрөнгийг 2013 оны төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д. Отгонбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д. Жаргалсайхан)-т даалгасугай.

САЙД

Н. ХҮРЭЛБААТАР

159

Эрүүл мэндийн сайдын
2012 оны 7 сарын 9 өдрийн
250 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**Аймгийн Нийгмийн эрүүл мэндийн
төвийн үлгэрчилсэн дүрэм**



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төв /цаашид төв гэх/ нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий эрүүл мэндийн үйлчилгээний байгууллага мөн.

1.2. Төв нь үйл ажиллагаандаа нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, Эрүүл мэндийн тухай болон бусад холбогдох хууль, тогтоомж, тушаал, дүрэм, заавар, стандарт, удирдамжийг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Нийгмийн эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, зонхилон тохиолдох өвчлөл, түүний эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх үйл ажиллагааг дангаараа болон бусад эмнэлэг, мэргэжлийн төвүүд, салбар, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулна.

1.4. Төв нь тогтоосон журмаар хийгдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ. Өөрийн онцлогийг илэрхийлсэн бэлгэдэлтэй байж болно.

Хо р . Төвийн чиг үүрэг

2.1. Монгол улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг өөрийн үйл ажиллагааныхаа хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах.

2.2. Байгууллагынхаа боловсон хүчний хэрэгцээг тодорхойлж, тэднийг бэлтгэх, даван сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, ажиллагчдын хөдөлмөрийн хэвийн нөхцөл, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.3. Үйл ажиллагааныхаа хүрээнд төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах

2.4. Хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаандаа дагаж мөрдөх заавар, дүрэм, журам боловсруулж мөрдүүлэх, биелэлтэд нь хяналт тавьж, илэрсэн гажуудал, дутагдлыг арилгах.

2.5. Үйл ажиллагааных нь чиглэлээр гаргасан иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх.

2.6. Хууль тогтоомж, байгууллагын дүрэм, дотоод журмыг зөрчсөн албан тушаалтанд хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хариуцлага хүлээлгэх.

2.7. Байгууллагын эзэмшилд байгаа төрийн өмчийг зохистой ашиглах, ашиглалтын байдалд хяналт тавих, хадгалах, хамгаалах зохицуулах арга хэмжээ авах.

2.8. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, чиг үүрэгт хамаарах асуудлаар гадаад орнуудын ижил төрлийн болон олон улсын холбогдох байгууллага, хүмүүстэй хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулан хэрэгжүүлэх

Гурав. Төвийн удирдлага, зохион байгуулалт

3.1 Төв нь аймгийн Эрүүл мэндийн газрын шууд удирдлага дор ажиллана.

3.2 Төв нь халдварт бус болон халдварт өвчний тандалт, сэргийлэлтийн алба, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний алба, нийгмийн эрүүл мэндийн лаборатори, захиргаа, нийтлэг үйлчилгээний албатай байна.

3.3. Төв нь өрхийн болон сумын эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.4. Төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг төр хариуцна.

3.5. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр нь улсын төсөв, орон нутгийн эрүүл мэндийг дэмжих сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэж болно.

Дөрөв. Төвийн эрх , үүрэг

Төвийн эрх:

4.1. Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар улсын болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үнэлгээ, зааварчилга, мэргэжлийн зөвлөгөө, үүрэг даалгавар өгөх, шаардлага тавих, мэдээлэл авах;

4.2. Өөрийн орны болон гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, гэрээ хэлцэл хийх;

4.3. Орон нутгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй нийгмийн эрүүл мэндийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, арга зүйгээр хангаж, хэрэгжилтийг хянах, тайлагнах;

4.4. Хуулиар олгогдсон бусад эрх.

Төвийн үүрэг:

4.5. Эрүүл мэндийн талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан эрхийн акт, норм, норматив, стандарт, удирдамж, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, шаардлагыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх;

4.6. Орон нутагт нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлого, чиглэлийг тогтоох, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, стратегийг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах;

4.7. Харъяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах;

4.8. Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд халдварт болон халдварт бус өвчний тандалт судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион явуулах, өвчин үүсгэж буй халгаат хүчин зүйлийн эсрэг авах арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж хэрэгжүүлэх;

4.9. Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийж, зонхилон тохиолдож буй өвчин эмгэгийг илрүүлэн эрт үед нь оношлох, эмчлэх шат дараатай арга хэмжээг удирдан зохион байгуулах;

4.10. Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;

4.11. Хүн амыг биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр чийрэгжүүлэх, сэргээн засах болон эрүүл, зөв хооллолтыг хөхүүлэн дэмжих, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх чиглэлээр чийрэгжүүлэлтийн, халдварт бус өвчлөл, хоол зүйн, сэтгэл зүйн, донтолтын, хүчирхийллийн зөвлөгөө өгөх болон Өсвөр үе, ахмадын эрүүл мэндийн нэгжийг байгуулан ажиллуулж болно.

4.12. Тухайн орон нутагт дахь хүрээлэн байгаа орчны бохирдол, эрсдэлт хүчин зүйлийг тооцох, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг нотолгоонд тулгуурлан үнэлэх, дотоодын хяналт, тандалт судалгаа хийх, нийгмийн эрүүл мэндийн лаборатори байгуулан ажиллуулах;

4.13. Судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулж, нийгмийн эрүүл мэндийн мэдээний сан бүрдүүлэх;

4.14. Хууль, тогтоомж, тушаал шийдвэрээр заагдсан бусад үүрэг.

Тав. Төвийн үйл ажиллагааны чиглэл

5.1. Төв нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон дээд шатны бусад байгууллагаас гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, зохицуулах, хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэй ажиллана.

5.2. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн зорилт, стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.

5.3. Харъяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоож, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлогыг тодорхойлох, түншлэл болон хамтын ажиллагааг дэмжих замаар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулна.

5.4. Төв нь харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

5.5. Эрүүл мэндийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт гарган өгч, холбогдох байгууллагуудад хугацаанд нь мэдээлж, үйл ажиллагаатай нь холбоотой эргэх мэдээллээр хангаж ажиллана.

5.6. Байгууллагын материаллаг бааз, барилга, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, нөхөн хангалтыг нэгтгэн зохион байгуулна.

5.7. Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар салбар дундын зохицуулалтыг хангаж, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, олон нийтийг татан оролцуулж, хамтарч ажиллана.

Зургаа. Хамтын ажиллагаа

6.1. Төвийн төсөв, санхүүжилттэй холбоотой үйл ажиллагаа нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон төсөв санхүүтэй холбоотой бусад хуулиар зохицуулагдана

153

6.2. Төв нь төрийн сангийн зардлаар эмч мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах захиалгаа аймгийн эрүүл мэндийн газраар дамжуулан ЗГХА- Эрүүл мэндийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ,

6.3. Төв нь урсгал санхүүжилт, хөрөнгө оруулалтын талаар тулгамдаж байгаа асуудлаар тухай бүр аймгийн Засаг даргын тамгын газарт хүсэлт гаргаж, шийдвэрлүүлнэ,

6.4. Төв нь үйлчлэх хүрээний аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй хамтарсан төлөвлөгөөний биелэлтийг жил бүр хэлэлцэж, үр дүнг тооцон, цаашид авах арга хэмжээг төлөвлөн, нягт хамтран ажиллана,

6.5. Төв нь судалгааны төслийн санал, боловсруулан холбогдох байгууллагад захиалга хүргүүлнэ

-oOo -

Эрүүл мэндийн сайдын
2012 оны 7-р сарын 9-н өдрийн
... дугаар тушаалын хоёрдугаар хавцалт

Аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэл

Аймгийн Эрүүл мэндийн газар

Аймгийн нийгмийн эрүүл мэндийн төв

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний алба

- НЭМ-ийн тусламж, үйлчилгээний зохицуулалт
- Нөхөн үржихүйн эрүүл мэнд
- Өсвөр үеийн эрүүл мэнд
- Ахмад настны эрүүл мэнд
- Эрүүл мэндийн сургалт сурталчилгаа
- Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ, тандалт судалгаа
- Орчны эрүүл мэнд
- Олон нийтэд хүрч очих оролцоог хангах

ХБӨ-ний тандалт, сэргийлэлтийн алба

- Халдварт бус өвчний асуудал
- Хүнсний аюулгүй байдал
- Эрүүл мэндийг дэмжих, салбар хоорондын зохицуулалт
- Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийн тандалт
- Сэтгэц, зан үйлийн эрүүл мэнд
- Архи, тамхи, донтолт
- Цийрэгжүүлэлт, биеийн тамир
- Эрүүл хооллолт, хоол тэжээл

Халдварт өвчний тандалт, сэргийлэлтийн алба

- Халдварт өвчний асуудал
- Амьсгалын замын халдвар
- Эмнэлгээс шалтгаалах халдвар, ариутгал
- Гэдэсний халдвар
- Сүрьеэ

Голомтын халдваргүйт гэл

неөцийн
тасаг

- Халдвартын их эмч
- Бага эмч
- Ариутгагч
- Жолооч

Дархлаажуула лтын тасаг

- Их эмч
- Бага эмч, нөөц хангалт сувилагч
- Дархлаажуу лалт, халдвар судлал

Нийгмийн эрүүл мэндийн лаборатори

- Хор судлалын лаборатори
 - их эмч
 - химик
 - лаборант
- Шим судлалын лаборатори
 - их эмч
 - лаборант
- Эрүүл зүйн лаборатори
 - их эмч
 - лаборант
- Орчны эрүүл мэнд лаборатори
 - их эмч
 - лаборант
- Нян судлалын лаборатори
 - их эмч
 - бактериологи лаборант

Захиргаа, нийтлэг үйлчилгээний алба

- Дарга
- Нябо
- Мэдээлэл зүйн ажилтан
- Жолооч
- Үйлчлэгчид
- манаач
- архив, бичиг хэрэг
- дүн бүртгэл, статистикч